

ЦАГДААГИЙН ХЭСГИЙН БАЙЦААГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ТҮҮНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Баасансүрэнгийн Сарангуя
Орхон аймгийн ЦГ-ын хэсгийн байцаагч,
магистрант, цагдаагийн ахлах дэслэгч

Цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тодорхой нутаг дэвсгэр, засаг, захиргааны нэгжид бие даан хэрэгжүүлж байгаа хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны орчин, нөхцлийг судлах, тулгамдаж буй асуудлыг нээн илрүүлэх асуудал өнөөдөр чухлаар тавигдаж байна.

Хариуцсан нутаг дэвсгэртээ цагдаагийн байгууллагын бүх чиг үүргийг хэрэгжүүлэхэд гэмт хэрэг, захиргааны зөрчилтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах ажлыг бие даан зохион байгуулагч гол хүч юм.¹

Цагдаагийн хэсгийн төлөөлөгч, байцаагчийн ажлын амжилтанд хүрэх нөхцөл нь хариуцсан хэсгийнхээ өөрчлөгдөж буй нөхцөл байдлаа өдөр тутам мэдэж үнэлэх, ажлаа ухаалгаар төлөвлөх замаар албаны цагаа ашигтай зарцуулах, үйл ажиллагаандаа илүү тохиромжтой тактикийн арга барилыг сонгож хэрэглэх, нийгмийн хэв журам хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх ажлын туршлага, шинжлэх ухаан, техникийн ололтыг өргөнөөр нэвтрүүлэх, хамтран ажиллах зүй зохистой орчинг бүрдүүлэхэд оршино.²

Иймээс би хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны төлөв байдлыг нээн харуулах, ажлын нөхцөл байдалд үнэлгээ өгөх, тэднээс чиг үүргээ хэрэгжүүлэхэд учирч буй саад бэрхшээлийг нээн илрүүлэх, шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх зорилгоор нийслэлийн 6 дүүргийн нийт 97 хэсгийн байцаагчийн хүрээнд хэсэгчилсэн судалгаа явууллаа.

Судалгааны явцад зарим нэг судалгааны хариу анхаарал татаж байлаа. Тухайлбал хэсгийн байцаагчийн ажлын байрны тодорхойлолтод зааснаар хэсгийн байцаагчаар эрх зүйч-цагдаагийн байгууллагын ажилтан мэргэжилтэй хүнийг ажиллуулахаар заасан бөгөөд практикт энэ шаардлага хэрхэн хангагдаж буйг үнэлэх зорилгоор судалгаанд оролцсон нийт 97 хэсгийн байцаагчийн боловсролын байдлыг харьцуулан нэгтгэвэл 85 буюу 87.0% нь хууль зүйн бакалаврын зэрэгтэй, 7 буюу 7.2% нь хууль зүйн дээд боловсролтой, 3 буюу 3.0% нь хууль зүйн бус дээд боловсролтой байна. өөрөөр хэлбэл энгийн их дээд сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгссөн маш олон иргэн хэсгийн байцаагчаар ажиллаж байгааг харж болно.

Нөгөө талаар хэсгийн байцаагч нь хариуцсан нутаг дэвсгэрийнхээ ард иргэдийн дунд нэр хүнд сайтай, үйл ажиллагаа ил тод, хуулийн хүрээнд явуулж, тодорхой амжилтанд хүрч байж гэмээн цагдаагийн байгууллагын нэр хүнд өсөх үндэс нь болж байдаг.

Тиймээс бид хэсгийн байцаагчдын ажлын дадлага, туршлага, ажилласан жилийг анхаарч үзэх нь чухал юм. Судалгаанаас харвал 58 буюу 59.7% нь 1-3 жил, 13 буюу 13.4 нь 3-5 хүртэл жил, 5 буюу 5.1 нь 5-8 жил, 21 буюу 21.6 хувь нь 8-аас дээш жил ажилласан. Энэ нь хэсгийн байцаагчаар ажиллаж байгаа нийт алба хаагчдын дийлэнхи нь шинэ залуу боловсон хүчин байгаа нь тэдэнд ажлын туршлага дутах явдал гарч байгаатай салшгүй холбоотой юм.

¹ Д. Таванжин. Монгол улсын цагдаагийн эрх зүй. УБ. 2006. 149 дэх тал

² Ж. Долгорсүрэн. Монгол улсын цагдаагийн эрх зүй. УБ. 2004. 112 дах тал

Сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотын хүн амын нягтрал өдрөөс өдөрт нэмэгдэж байгаатай холбоотойгоор хот зохион байгуулалт оновчтой бус хэлбэрээр хийгдэж, иргэдийн шилжин суурьших явдал ихэссэнтэй холбоотойгоор зарим өрх айлын байршил, хаяг тодорхойгүй байдлыг ихээр үүсгэж байгаа нь хэсгийн байцаагчдын үйл ажиллагааны хэвийн нөхцлийг алдагдуулах нэг шалтгаан болж байна.

Хэсгийн төлөөлөгч, байцаагч нь хариуцсан хэсгийнхээ нутаг дэвсгэрийн хэмжээ, хил зааг, гудамж талбай, цэцэрлэг, цэнгэлдэх хүрээлэн, үзвэр үйлчилгээний болон олон нийтийн бусад газар, гэр байшин, хашааны эзэмшигч, орох гарах үүд хаалга, албан газар, байгууллага, дэлгүүр, ресторан, банкны салбар, касс, үнэт материалын агуулахын байрлал, тэдгээрийн ажиллах цаг, хамгаалалтын байдал, түүнчлэн төр, захиргаа, олон нийтийн байгууллагын хаяг, харилцаа холбоо барих арга, гудамж замын нэвтрэх хэсэг, нийтийн тээврийн зорчих хэсэг, зогсоол буудал, тээврийн хэрэгсэл, явган зорчигчдын нягтрал зэргийг урьдчилан судалж нарийн мэдсэн байвал зохино.³

Тиймээс судалгаанд оролцсон хэсгийн байцаагчдын ажиллаж буй нутаг дэвсгэрийн онцлогийг тодруулан үнэлэх зорилгоор явуулсан санал асуулгад давхцсан тоогоор нийт нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгжийн 40 орчим хувь нь гэр хороолол ихтэй гэж үнэлсэн байхад үлдсэн хэсэг нь шилжин суурьшигчид ихтэй зэргээр үнэлжээ. Энэ нь хэсгийн байцаагчийн ажлын ачаалал ихсэх, үйл ажиллагааны үр нөлөө буурах шалтгаан болж байна.

Түүнчлэн хэсгийн байцаагчаар ажиллахын давуу талыг тодруулах үүднээс, нээлттэй хэлбэрээр асуулга явуулахад судалгаанд хамрагсдын 42 буюу 68% нь цагдаагийн бусад алба хаагчдыг бодвол иргэд, ААН-тэй ойр дотно ажилладаг гэж үнэлсэн байхад, 16 нь буюу 16.4 хувь нь ард иргэдэд нэр хүндтэй, анхдагч нэгж гэдэг утгаараа их зүйл сурах боломжтой хэмээн үнэлжээ. Харин үлдсэн 15 нь буюу 15.4 хувь нь ямар нэг давуу тал байхгүй хэмээн үнэлжээ.

Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 33-38-р зүйлд заасан алба хаагчийн нийгмийн баталгаа хэрхэн хэрэгжиж буйг үнэлэх үүднээс хэсгийн байцаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар төр, засгийн хэрхэн анхаарал тавьж байгаа талаарх асуулга явуулахад судалгаанд хамрагсдын 41 нь буюу 62.8 хувь нь хангалтгүй буюу огт хангалтгүй хэмээн хариулсан байхад 19 нь 37.1 хувь нь зарим талаараа асуудлыг шийдвэрлэдэг хэмээн үнэлжээ.

Хэсгийн байцаагчаас хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байдлыг нэрлэнэ үү гэсэн асуулгад давхардсан тоогоор судалгаанд хамрагсдын 31 нь буюу 51.5 хувь нь байнга илүү цагаар ажилладаг /7 хоногт дунджаар 60-аас дээш цаг ажилладаг гэж 86 хувь нь хариулжээ/ гэж хариулсан байхад 60 нь буюу 61.8 хувь нь унаа машин болон холбооны хэрэгсэл байхгүй гэж хариулжээ. Мөн, 20 нь тусгай хэрэгслийн хангалт муу, 40 нь хүн ам, нутаг дэвсгэрийн хэмжээ их, 37 нь ажлын байрны нөхцөл муу, 50 нь хэт олон төрлийн ажиллагаа явуулдаг, ажлын ачаалал хэт их хэмээн үнэлжээ.

Мөн та ажлынхаа ихэнхи цагийг ямар ажилд зарцуулдаг вэ гэсэн асуултанд давхцсан тоогоор 56 нь өргөдөл, гомдол, эрүүгийн хэрэг шалгахад 72 нь зөрчил гаргасан хүнийг шүүхээр баривчлуулахад 22 нь байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхөөр орж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил явуулахад, 6 нь эргүүлд гарахад гэж хариулсан бөгөөд айл өрхөөр явахад иргэд илт дургүйцдэг, гэртээ оруулдаггүй, нохой нь сул байдаг, өдрийн цагаар хүнгүй байдаг гэсэн хүндрэлүүдийг дурджээ.

³ Ж. Долгорсүрэн. Монгол улсын цагдаагийн эрх зүй. УБ. 2004. 114 дах тал

Хэсгийн байцаагч нь төр, цагдаагийн байгууллагын өмнө тавигдаж байгаа олон талт үүргийг иргэд олон нийтийн дунд хэрэгжүүлэх үүргийг хүлээсэн төрийн тусгай чиг үүргийн алба хаагч мөн бөгөөд түүнийг ажил гүйцэтгэх чадвар, мэргэжлийн мэдлэг, ур чадвар өндөртэй, харилцааны соёлтой, үнэнч шудрага, шуурхай байхыг иргэд, олон нийт шаарддаг. Хэсгийн байцаагч дээрх чадварыг бүрэн эзэмшсэнээр өөрийн нэр хүнд өсөөд зогсохгүй цагдаагийн байгууллагын нэр хүндэд шууд нөлөөлнө.

Хэсгийн байцаагчийн ажлын зааварт “Хэсгийн байцаагчийн ердийн ажлын үргэжлэх хугацаа 8 хүртэлх цаг байна” гэж заасан боловч “Тухайн нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын улмаас цагдаагийн байгууллагын даргын шийдвэрээр уртасгасан цагаар ажиллаж болно. Энэ тохиолдолд боломжтой өдөр тэр хугацаагаар нөхөн амруулна” гэсэн зохицуулалтыг тусгажээ. Мөн зааварт зааснаар хэсгийн байцаагч нь долоо хоногийн Бямба, Ням гаригт амрах бөгөөд хэрэв ажлын шаардлагаар амарч чадаагүй тохиолдолд өөр гаригт амруулахаар заажээ.

Гэтэл нийслэлийн хэмжээнд явуулсан бидний хэсэгчилсэн судалгааны дүнгээс харахад хэсгийн байцаагчдын 60-аас илүү хувь нь байнга илүү цагаар ажилладаг тэр дундаа 7 хоногт дунджаар 60-аас дээш цагаар ажилладаг, амралтын өдрүүдэд мөн ажилладаг зэрэг хүндрэлүүдийг тоочсоноос харахад хэсгийн байцаагчдын Үндсэн хуулиар хүн бүрт тэгшээр олгогдсон үндсэн эрхийн нэг болох хөдөлмөрийн ая таатай нөхцлөөр хангуулах эрх ихээр зөрчигдөж байгааг харуулж байна.

Мөн 2007 оны Нийслэлийн цагдаагийн газрын Б/19 тоот тушаалаар “Хэсгийн байцаагч, хорооны цагдаагийн ажлын цагийн хуваарь”-ийг баталсан нь мөн л “Тухайн нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын улмаас цагдаагийн байгууллагын даргын шийдвэрээр уртасгасан цагаар ажиллаж болно. Энэ тохиолдолд боломжтой өдөр тэр хугацаагаар нөхөн амруулна” гэсэн хэсгийн байцаагчийн ажлын зааврын заалтын хүрээнд хийсэн зохицуулалт мөн бөгөөд харамсалтай нь уртасгасан цагаар ажиллуулсны төлөө нөхөн амрах талаарх заалтыг хэрэгжүүлж байгаа дарга алга байна.

Хэсгийн байцаагч нь ердийн ажлын өдрийн ажиллах хугацааны 70-аас доошгүй хувийг тухайн хариуцсан нутаг дэвсгэр дэх хүн амын амгалан амьдрах нөхцлийг бүрдүүлэх, иргэд, олон нийт цагдаагийн байгууллагын харилцан хамтын ажиллагааг сайжруулах, гэмт хэрэг, зөрчил үйлдэж болзошгүй хүмүүсийг илрүүлж, хяналтад авах, захиргааны хяналтад байгаа хүмүүстэй ажиллахад зарцуулахаар зааварт заажээ.

Гэвч хэсгийн байцаагчид нь цагдаагийн байгууллагын захиргааны үүргийн олон талт ажиллагааг биечлэн гүйцэтгэхээс гадна цаг үеийн болон өөр бусад ажилд дайчлагддагаас хариуцсан хорооныхоо нутаг дэвсгэр дээр гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг тасралтгүй явуулах, иргэд, оршин суугчдын дунд ил тод ажиллах, судалгаа бүртгэл хийж, хяналт тавих ажил өнөөгийн шаардлагын хэмжээнд хүрээгүй зэрэг нийтлэг дутагдлууд оршсоор байна.

Хэсгийн байцаагчийн ажлын зохион байгуулалтын чиглэлээр хийсэн 25 хэсгийн байцаагчдын дунд “Фокус”⁴ ярилцлагын болон анкетын аргаар хийсэн судалгаанаас харахад судалгаанд хамрагдсын 50-иас илүү хувь нь хэт олон төрлийн үйл ажиллагаа явуулдаг, ажлын ачаалал их, байнга илүү цагаар ажилладаг, 60 хувь

4. Iadeea-eenaai noaadeaaaii nyaayyo iyayyee oaoeooeaa -eaeenyi aeaai, niu aon yialee oyaeayoyo ydeoeaaa °di:ee aoe
 oooi oiiu di:eehee aeaeaa oyeiy. Noadeaaaii cideei, oaidao di:oyoye oyeai di:eehee oia daadeoi aaeae e oiaonia.
 /aayva dae iu 12 di:/.

нь ажлын ихэнхи цагийг өргөдөл, гомдол, эрүүгийн хэрэг шалгахад, 12 хувь нь зөрчил гаргасан хүнийг шүүхээр баривчлуулахад, 12 хувь нь байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхөөр орж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил явуулахад, 16 хувь нь эргүүлд гарахад гэсэн хариулт өгсөн байна.

Энэ бүхэн нь хэсгийн байцаагчаас хэт олон төрлийн ажилд самгардах байдлыг үүсгэж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг сулруулахад тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаа гэдэгт эргэлзэхгүй байна.

Энэ бүхнийг гаргуулахгүй байх үүднээс Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн актын дагуу ажиллуулж буй урамшуулалт болон нийтийн эргүүлийг бага боловч ажиллуулж, төрийн бус зарим байгууллагатай хамтран ажиллаж байгаа нь бага боловч дэм болдог байна.

Гэхдээ өнөөдөр урамшуулалт эргүүлд өгч байгаа урамшуулал нь бага байгаагаас сүүлийн үед ард иргэдээс эргүүлд ажиллах нь буурч байгаагийн дээр төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа тогтворжоогүйгээс байнгын хамтран ажиллагч иргэний нийгмийн байгууллагууд хуруу дарам цөөн байна.

Нутаг дэвсгэрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс хэсгийн байцаагч нарт 7 хоногт 6-8 санал хүсэлт ирдэг гэж 51 хувь нь хариулсан байгаа нь санал хүсэлтийг авч шийдвэрлэх нөхцөл боломжийг тэдэнд бүрдүүлж өгөх ажлыг тухайн хэлтэс, тасгууд зохион байгуулах шаардлагатай байгааг харуулж байна.

Хэсгийн байцаагч нараас хэлтэс дээр рапортанд сууж, хэрэг зөрчлийн мэдээтэй танилцах ажиллагаа 7 хоногт 2 өдөр байвал зохимжтой гэж 37.7 хувь нь хариулсан байна. Оршин суугчид, иргэд ихэвчлэн өглөө 09-12 цагийн хооронд хороон дээр ирэхэд хэсгийн байцаагч энэ үед рапортанд суухаар хэлтэс дээр очсон байдаг. Энэ байдлаас болж хэсгийн байцаагч ажиллахгүй байна гэсэн ойлголт иргэдэд төрдөг учир хэсгийн байцаагч нарыг хэлтэс очдог өдрийг аль болохоор багасгах нь зүйтэй.

Цагдаагийн хэлтэс, тасгийн дарга нар хэсгийн байцаагчийн ажлыг биечлэн үзэж зааварчилж, удирдлагаар хангах явдал сул, тэднээс ажил шаардахаас бус ямар нөхцөлд хэрхэн ажиллаж байгааг анзаардаггүй, ажлын ачааллаар хэт дарж, амралт чөлөөгүй ажиллуулснаас болж зарим хэсгийн байцаагч шантарч өөр ажил, газарт шилжих, бүр халагдах ч байдал нэлээдгүй байна.

Хэсгийн байцаагчдыг нэг хороонд тогтвор суурьшилтай ажиллуулдаггүй, 1-3 жил тутамд өөрчлөн томилдогоос тухайн алба хаагчид хариуцсан хорооныхоо эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг бүрэн мэдэрч чаддаггүй, хийвэл зохих бүртгэл судалгааг эхлэлийн төдий хийж, дараагийн алба хаагчид шилжүүлдэг нь тэдний ажлын үр дүнд муугаар нөлөөлж байна.

Хэсгийн байцаагч хорих газраас суллагдсан болон хорихоос өөр төрлийн ял шийтгэлтэй хүнд захиргааны хяналтын хэрэг нээн нэг бүрчилсэн арга хэмжээг зохион байгуулж байгаа ч хяналт тавигдвал зохих хүмүүсийн шүүхийн тогтоол дээр тухайн хүний ял эдлэхээс өмнөх үеийн оршин сууж байсан болон түр оршин сууж байсан хаяг, огт амьдарч байгаагүй хаяг ч ирдэг нь энэ ажлыг зохих түвшинд явуулахад хүндрэл учруулдаг байна.

Мөн цагдаагийн алба хаагч нь Цагдаагийн байгууллагын тухай хууль болон холбогдох заавруудад заасны дагуу хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд тусгай хэрэгсэл хэрэглэх эрхтэйн дээр хөдөлмөрийн ая таатай нөхцлөөр хангуулах эрхтэй гэж заасан боловч бидний явуулсан судалгааны дүнгээс харахад хэсгийн байцаагчдын тусгай хэрэгслийн хангалт муу, унаа, холбооны хэрэгсэл дутагдалтай, ажлын байрны нөхцөл шаардлага хангадаггүй зэрэг талаар саналаа илэрхийлсэн байна.

Өнөөдөр хэсгийн байцаагч нь, хэсгийн байцаагчийн ажлын зааварт заасан үндсэн үүргээ биелүүлэхийн зэрэгцээ хэрэг бүртгэх ажиллагаа явуулж байгаа нь тэднийг хариуцсан нутаг дэвсгэртээ ажиллах, ард иргэдтэй ойр дотно байж хамтран ажиллах нөхцөл боломжийг бууруулж байгаа бөгөөд улмаар ажлын ачаалал нь гагцхүү өргөдөл, гомдол, мэдээлэл болон эрүүгийн хэрэг шалгахад чиглэгдэж байгаа нь эрх зүйн зохицуулалт буруу байгаатай холбон үзэж байна.

Энэ бүхнээс үзэхэд, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг нутаг дэвсгэрийн засаг захиргааны анхан шатны нэгж дээр бие даан хэрэгжүүлж байдаг албан тушаалтан бол хэсгийн байцаагч бөгөөд тэдэнд техник хэрэгсэл, унаа, холбоо мэдээллийн хангамж байдаггүй, ажил үүргийн дагуу маш олон ажил зэрэг хариуцдаг, үндсэн үүргээ гүйцэтгэхийн оронд бичиг цаастай их зууралддаг, цагдаагийн байгууллагын төрөл, мэргэжлийн албан тушаалтнууд дотроос хамгийн их ажлын ачаалалтай ажилладаг, олон төрлийн ажил үүргийг хамааруулан гүйцэтгэдэг ачаалал ихтэй ажилтан болох нь харагдаж байна.